



МОНГОЛ УЛСЫН  
ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 410

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалт, Далайн захиргааны дүрмийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.2.10 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Далайн захиргааны "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгөх тухай журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Усан замын тээврийн хяналтын камер болон аврах завини техникийн ашиглалт хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаа өгөх журам"-ыг хоёрдугаар хавсралтаар, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгааны бүртгэлийн маягтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх журмыг үйл ажиллагаандaa мөрдөж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн зааварчилгааг өгөх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Ю.Өлзийжаргал)-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Далайн захиргааны даргын 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 67 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



00000219

Далайн захиргааны даргын 2024 оны  
56. дугаар сарын 01-ны өдрийн 10 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

902ГС00012  
ТУЗ2106 А 5201016

## ДАЛАЙН ЗАХИРГААНЫ АЖИЛТНУУДАД ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХҮЙН ЗААВАРЧИЛГАА ӨГӨХ ЖУРАМ

### Хамрах хүрээ

Энэхүү хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг Далайн захиргааны орон тоо, бүтцийн болон гэрээгээр ажиллаж байгаа нийт албан хаагчид дагаж мөрдөнө.

### Зорилго

Ажилтан ажил үүргээ гүйцэтгэх явцад гэмтэж бэртэх, болзошгүй осолд орох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагаанд сургах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг оновчтой зохион байгуулахад оршино.

### Аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх журам

- Байгууллага нь MNS 4969:2000 стандартыг хэрэгжүүлж, нийт ажилтнуудад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг зааварчилгаа өгөх хэлбэрээр тасралтгүй зохион байгуулна.
- Аюулгүй ажиллагааны зааварчилгааг холбогдох ажилтан өгч, зааварчилгааны маягт, дэвтэрт тэмдэглэн, гарын үсгээр баталгаажуулна.
- Эрх бүхий албан тушаалтан аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажилтны албан тушаал, тухайн үед гүйцэтгэх ажилд нь тохируулан зайлшгүй мэдэж байх заалтуудыг бүрэн хэмжээгээр тусгаж, танилцуулж өгөх үүрэгтэй.
- Ажилтан бүр ажил гүйцэтгэхийн өмнө ажил үүрэгтэйгээ хамааралтай аюулгүй ажиллагааны зааварчилгааг заавал авсан байна.
- Аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч, гарын үсэг зураагүй ажилтныг тухайн ажлыг гүйцэтгэхийг хориглоно.
- Урьдчилсан зааварчилгаа:** Шинээр ажилд орсон ажилтан, сургалт дадлагын оюутан, суралцагчдад хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөлийн гишүүн 2 цагаас багагүй хугацаагаар танхимаар өгнө. Зааварчилгаанд хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, техникийн аюулгүй ажиллагаа, галын аюулгүй байдал болон албаны ажлын онцлог, Хөдөлмөрийн дотоод журам хамрагдана.
- Анхан шатны зааварчилгаа:** Ажилтны ажлын байр, албан тушаал, хэлтэс тасаг өөрчлөгдөх, мөн урьдчилсан зааварчилгааг авсан шинээр ажилд орсон ажилтан, дадлагын оюутан, суралцагчдад Захиргаа, удирдлагын хэлтэс, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн, тухайн хэлтсийн удирдах албан тушаалтан өгнө.
- Ажлын байран дахь анхан шатны зааварчилгааг өгсөн ажилтан шалгалт авч, хангалттай гэж үзвэл уг ажилтанд бие даан ажиллах зөвшөөрөл олгоно.
- Давтан зааварчилгаа:** Ажилтанд өмнө олгосон мэдлэгийг бататгах зорилгоор ажлын байран дахь анхан шатны зааварчилгааны агуулгаар Захиргаа, удирдлагын

хэлтэс, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн мэргэжилтэн өгнө.

10. **Ээлжит давтан зааварчилгаа:** Улиралд нэгээс доошгүй өгөгдөх бөгөөд шинэ автомашин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, технологи нэвтрүүлэх, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөгдөх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм өөрчлөгдөх, шинэчлэгдэх үед ээлжит хугацаанаас өмнө өгнө.
11. **Ээлжит бус давтан зааварчилгаа:** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, зааврыг ноцтой зөрчсөн, мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвдсөн, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод орсон, нэг сараас илүү хугацаагаар ажлаас хөндийрч яваад эргэж ажилдаа орсон ажилтанд өгнө.
12. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулах, сайжруулах, шинэчлэхийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн холбогдох ажилтнуудтай хамтран гүйцэтгэж, байгууллагын даргын тушаалаар батлуулна.
13. Ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгааг жолооч, гэрээт сахиул болон тухайн үед үндсэн ажил үүргээс өөр ажил гүйцэтгэх ажилтанд, давтан зааварчилгааг Далайн захиргааны орон тоо, бүтцийн болон гэрээгээр ажиллаж байгаа нийт албан хаагчид албан томилолтоор орон нутагт ажиллах тохиолдол бүрд өгнө.
14. Ажлын онцлогоос хамааран аюулгүй ажиллагааны заалтуудыг Захиргаа, удирдлагын хэлтэс (ЗҮХ) болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн) боловсруулна.
15. Зааварчилгаа нь товч тодорхой байх ба ажил эхлэхийн өмнө бичгээр өгөгдөнө.
16. Өдөр тутмын зааварчилгааг дараах ажилтнууд өгнө. Үүнд:
  - Захиргаа, удирдлагын хэлтэс— Хэлтсийн дарга
  - Усан замын тээврийн бүртгэл, хяналтын хэлтэс-Хэлтсийн дарга
  - Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын хэлтэс-Хэлтсийн дарга
  - Хуурай боомт, далайн тээврийн хэлтэс- Хэлтсийн дарга
17. Өдөр тутмын зааварчилгаа өгөх ажилтан эзгүй үед ЗҮХ-ийн дарга өгнө.
18. Өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгааны хэрэгжилтэд ЗҮХ, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн тогтмол хяналт тавина.
19. Байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааны мөрдөлтөд Хяналт шинжилгээ, дотоод аудит /ХАБЭА/ хариуцсан мэргэжилтэн хяналт тавина.
20. ЗҮХ, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтнүүд Хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаанд тогтмол хяналт тавина.
21. Хяналт шинжилгээ, дотоод аудит /ХАБЭА/ нь зааварчилгааны өөрчлөлтийг тухай бүрд нь бүртгэн албажуулна.

#### **Хөдөлмөрийн аюулгүй байдлын ерөнхий шаардлага**

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм, стандарт, технологийн горим, зааварчилгааг чанд мөрдөх;
2. Ажлын бус цагаар сайтар амарч, согтууруулах ундаа болон мансууруулах төрлийн бодис хэрэглээгүй байх;
3. Ажилтан ажил, үүрэгтэйгээ хамааралтай аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан байх;
4. Автомашин, тоног төхөөрөмжүүдийг ажиллуулахын өмнө техникийн бүрэн бүтэн байдлын үзлэгийг 15 минутаас багагүй хугацаагаар заавал хийх, шалгуулах;
5. Үзлэг үйлчилгээ хийхдээ цаг бугуйвч гэх мэт гүйдэл дамжуулах хэрэгсэл зүүхийг хориглоно.

6. Техникийн аюулгүй байдлын болон ашиглалтын стандартын шаардлага хангасан автомашин, механизмаар тээврийн ажил, үүрэг гүйцэтгэх;
7. Технологийн болон замын хөдөлгөөний дүрмийг чанд баримтлан ажил үүргийг гүйцэтгэх;
8. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх;
9. Өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх, амь нас эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх нөхцөлд аюулгүй байдлын дүрэм, журмын дагуу шуурхай арга хэмжээ авах;
10. Хувийн эрүүл мэндийн байдал муудсан, алжааж ядарсан үед ажил үүрэг гүйцэтгэхийг зогсоож, шууд удирдах ажилтанд мэдэгдэх;
11. Ажил, үүргээ осол эндэгдэлгүй гүйцэтгэх арга барил, мэргэжлийн ур чадвар эзэмших, болзошгүй аюул, ослын үед анхны тусламж үзүүлэх мэдлэгтэй байх;
12. Аюул, осолд өртсөн тохиолдолд мэдээллийг холбогдох албан тушаалтанд шуурхай мэдээлэх;
13. Ажлын байр, багаж хэрэгслийг эмх цэгтэй байлгаж, ажлаа илүү аюулгүй гүйцэтгэх арга барилаар ажиллахыг эрмэлзэх;
14. Ажлын байранд ноцолдох, хөөцөлдөх, гүйх, огцом чангаар гэнэтийн авиа гаргах, цочоох, тоног төхөөрөмж ажиллуулж байгаа үедээ элдэв зүйл ярих зэргээр хөдөлмөрийн сахилга батыг зөрчихгүй байх;
15. Ажлын байранд үнэт эдлэл /бөгж, бугуйвч, зүүлт г.м/ хэрэглэхгүй байх;
16. Хөдөлмөрлөж байх үед галын аюул, байгалийн гамшиг тохиолдох зэргээр онцгой байдал үүссэн нөхцөлд ажиллах үүргээ мэддэг байх;
17. Аюулгүй ажиллагааны дохио, санамж, тэмдэг, тэмдэглэгээг эзэмшсэн байх;

#### **Галын түймрийн аюулгүй байдлын зааварчилгаа**

1. Албаны ажлын байранд гал түймэр гарч байгаа тохиолдолд гал унтраах албанд нэн даруй мэдэгдэх;
2. Гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймрийг унтраах, авран хамгаалах сургалтад хамрагдаж, анхан шатны мэдлэг эзэмшсэн байх;
3. Галын анхан шатны багаж, хэрэгсэл ашиглах, гал унтраах хор, төхөөрөмжийг ажиллуулах чадвартай байх;
4. Гал түймрийн үед ажлын байрнаас дүрвэн гарах маршрут, нөөц хаалга, гарцыг мэддэг байх;
5. Гал түймрийн үед өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах талаар бололцоотой бүх арга хэмжээнд идэвхтэй оролцох;
6. Автомашины хөдөлгүүр бусад эд анги, тоног төхөөрөмжид гал гарсан тохиолдолд эсгий, элс шороогоор битүүмжлэх арга хэмжээ авах;
7. Цахилгаанаас гал гарсан тохиолдолд хүчдэлийг эх үүсвэрээс яаралтай салгах арга хэмжээ авах;
8. Өрөө тасалгаанд гал гарвал галын хорыг ашиглаж унтраахаас гадна галын дохиоллын системийг ажиллуулах арга хэмжээ авах;
9. Гараашт гал гарсан тохиолдолд галын багаж, төхөөрөмжийг ашиглан унтраахын зэрэгцээ машин техникуудийг яаралтай гаргах арга хэмжээ авах;
10. Аж ахуйн агуулахад гал гарсан тохиолдолд галын багаж, төхөөрөмжийг ашиглан унтраахын зэрэгцээ эд хөрөнгийг яаралтай гаргах арга хэмжээ авах;
11. Тамхийг зориулалтын цэгт татах, тамхины галыг бүрэн унтрааж байх;

Далайн захиргааны даргын 2024 оны  
06. дугаар сарын 01-ны өдрийн 01 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

6020030012  
ТУЗ2100 А 5292616

## УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН КАТЕР БОЛОН АВРАХ ЗАВИНЫ ТЕХНИКИЙН АШИГЛАЛТ, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗААВАРЧИЛГАА ӨГӨХ ЖУРАМ

Энэхүү техник ашиглалт, хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааны зорилго нь усан замын тээврийн хяналтын катер болон аврах завины үндсэн болон суурин тоног төхөөрөмж /дагалдах хэрэгсэл, аврах хэрэгсэл, шатахуун цэнэглэх/, эд анги, ажлын багаж хэрэгсэл зэргийн ашиглалт, засвар үйлчилгээг гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлага, техникийн баримт бичиг хөтлөх, мэргэжилтнүүдийн аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Ажилтан ажил үүргээ гүйцэтгэх явцад гэмтэж бэртэх, болзошгүй осолд өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааны талаар зөв дадлыг төлөвшүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгөх ажлыг оновчтой зохион байгуулахад чиглэгдэнэ.

### Хамрах хүрээ.

Энэхүү хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг усан замын тээврийн хяналтын катер болон аврах завь, усан зогсоол, гол, мөрөн, нуурын эрэгт буюу усны ойролцоо ажил үүргээ гүйцэтгэж байгаа, завин дээр зорчиж буй бүх этгээд дагаж мөрдөнө.

#### 1. Ерөнхий шаардлага:

Жолооч нь Монгол Улсын “Усан замын тээврийн тухай” хууль, “Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм”, “Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм” болон холбогдох стандартуудыг мөрдөж ажиллана.

Жолооч нь хуваарийн дагуу ажил үүргээ гүйцэтгэх ба зөвшөөрөгдөөгүй чиглэлд заагдаагүй ажил гүйцэтгэхийг хориглоно.

Усан замын тээврийн хэрэгслийн жолоодох эрхийн сургалтад хамрагдаж, эрх /үнэмлэх/ аваагүй хүнээр хяналтын катер, аврах завийг жолоодуулахыг хориглоно.

Ажилтан нь гал унтраах хэрэгслийг хэрхэн ашиглах талаар анхан шатны мэдлэг олгох дадлага, сургуултад хамрагдсан байна.

Хяналтын катер, аврах завийг шатахуунаар цэнэглэх, шатахуун юулэх үед ойр орчинд нь төрөл бүрийн цахилгаан хэрэгслүүд /гар утас, зөөврийн компьютер, г.м./ ашиглах, богино долгионы холбооны хэрэгслийг асаах, унтраахыг хориглоно.

## 1. УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖОЛООЧ АЯЛАД ГАРАХЫН ӨМНӨ АНХААРАХ ЗҮЙЛС

Хяналтын катер, аврах завины техникийн бүрэн бүтэн байдалд үзлэгийг хийж, бүрэн бус тээврийн хэрэгслийг ажилд гаргахгүй байх, өдөр бүр ажилчид ХАБЭА-н зааварчилгаа тогтмол авах бөгөөд аврах хэрэгслээ бүрэн зөв өмсөж ажил үүргээ гүйцэтгэнэ.

- 1.1. Усан замын тээврийн хэрэгсэлд зайлшгүй байх эд хэрэгслийг бүртгэж бүрэн бүтэн байдлыг шалгана. Үүнд:
  - Аврах хантааз;
  - Аврах цагариг;
  - Дуут дохио (шүгэл);
  - Гар чийдэн;
  - Аврах олс (10-20 метрийн урттай);
  - Хувин (завины ёроол цоорсон тохиолдолд усыг гадагшлуулах);
  - Сэлүүр;
  - Занггуу болон олс;
  - Анхан шатны тусламж үзүүлэх эмийн сан;
  - Засварын багаж хэрэгсэл орно.
- 1.2. Техникийн бүрэн бүтэн байдлыг шалгана. Үүнд:
  - Усан замын тээврийн хэрэгслийн их биеийн ёроолд ус орсон эсэх, их биеийн гадна, дотор талд цооролт, цууралт үүссэн эсэх;
  - Радио холбооны хэрэгсэл болон байршил тогтоох систем, (GPS) тоног төхөөрөмж хэвийн ажиллаж байгаа эсэх;
  - Аккумляторт богино холболт үүссэн, шингэн асгарч байгаа эсэхийг сайтар шалгана.
- 1.3. Хөдөлгүүрийн хэвийн ажиллагааг шалгана. Үүнд:
  - Шатахуун болон шатах тослох материалын хэмжээ хэвийн түвшинд байгаа эсэх;
  - Хөдөлгүүр асаахын өмнө хурдны хайрцагны удирдах хөшүүрэг нейтрал буюу N байрлалд шилжүүлсэн эсэхийг анхаарах;
  - Завь, катерыг зогсоолд бүрэн байрлуулж бэхэлсний дараа хөдөлгүүрийг асааж, унтраах;
  - Жолоодлого, залуурын ажиллагаа хэвийн эсэх
  - Хөдөлгүүрийн хөргөлтийн систем хэвийн ажиллах байгаа эсэхийг шалгана.
- 1.4. Зорчигчдын аюулгүй байдлыг хангах үүднээс дараах аюулгүй ажиллагааны зааварчилгааг зорчигчдод танилцуулна. Үүнд:
  - Аврах хантааз хэрхэн өмсөх талаар зааварчилгааг зорчигчдод танилцуулан аврах хантаазыг зорчигчдын тоогоор өмсгэх;
  - Зорчигчид усан замын тээврийн хэрэгслийн жолоочид шууд захирагдах үүрэгтэй;
  - Зорчигчид зөвхөн усан замын тээврийн хэрэгсэл жолооч /ахмад/- ийн зөвшөөрлийн дагуу усан замын тээврийн хэрэгсэл /завь, катер, усан онгоц/-д хуваарилсны дагуу суух;
  - Хяналтын катерыг савлуулах, усан замын тээврийн хэрэгслийн нэг талд бөөгнөрч хазайлт үүсгэхийг хориглох;
  - Хийлдэг завь болон жижиг оврын завин дээр зогсоогоор зорчихыг хориглоно.

Усан замын тээврийн хэрэгсэл, түүний нэмэгдэл тоног, төхөөрөмжийн үечилсэн үзлэг, засвар үйлчилгээ хийхтэй холбогдсон стандарт, зааврын талаар ойлголт өгөх. Үүнд: урьдчилан сэргийлэх үйлчилгээний ач холбогдол, засвар, үйлчилгээг төлөвлөх, аюулгүй байдлыг хангах, засвар үйлчилгээний ажилд байгууллагын хүлээх үүрэг, хариуцлага, засвар, үйлчилгээний бүртгэл хөтөлнө.

## 2. ХӨДӨЛГӨӨН ЭХЛҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС

- 2.1. Хөдөлгүүр аваарын унтраалгын хавлагийг жолоочийн аврах хантаазнаас болон гаранд бэхэлнэ. (Энэ нь тээврийн хэрэгсэл жолоодох, удирдлага алдагдсан үед автоматаар хөдөлгүүрийг унтрааж тээврийн хэрэгслийг зогсоох найдвартай арга юм);
- 2.2. Хөдөлгүүрийг бүрэн гүйцэд шалгаж ямар нэгэн доголдол ажиглагдаагүй нөхцөлд хөдөлгүүрийг асааж, хөдөлгөөнд оролцно;
- 2.3. Аврах завины хөдөлгүүр ажиллаж байх үед шаардлагагүй тохиолдолд радиаторын тагийг нээхгүй байх, хэрэв нээх тохиолдолд хөргүүрийн шингэн хэт халснаас халуун уураар тургиж, нүүр, гар тулэх аюултай тул болгоомжтой онгойлгох.
- 2.4. Завь, катерыг аялалд бэлтгэн, аялалд гаракаас өмнө салхи, давалгаа, усны урсгалын чиг, хүчийг тодорхойлох ба зогсоолоос хөдлөхдөө усны гүнд тохируулан хөдөлгүүрийн сэнсийг усны ёроолд цохигдохоос сэргийлж, хөдөлгүүрийг өргөх, сэнсний эргэлтийг давхар хянана;
- 2.5. Зогсоолоос хөдлөхдөө хөдөлгүүрийн сэнсний эргэлтийг хамгийн бага хурдаар эхлүүлэх ба зогсоол орчимд давлагаа үүсгэхгүй байхаар тооцно.
- 2.6. Хөдөлгүүр ажиллаж байх үед сэнс, туузан дамжуулга зэрэгт орооцлодож осолд орж болзошгүй тул элдэв зүүлт, алчуур, хүзүүний ороолт, гинж, бугуйвч, зангиа зүүх, ажлын бус хувцас өмсөхийг хориглоно.
- 2.7. Хяналтын катер, аврах завин дээр ажиллахдаа өндөр өсгийтэй болон хатуу ултай халтирах аюултай, мөн металл хадаастай болон тахтай гутал өмсөхийг хориглоно.

## 3. ЖОЛООДОГЧИЙН ЧАДАМЖ

Усан замын тээврийн хэрэгсэл, хяналтын катер жолоодогч нь дараах чадварыг бүрэн эзэмшсэн байна. Үүнд:

1. Завь, катерыг аюулгүйгээр жолоодон, 180 градусаар огцом эргэлт хийх;
2. Завь, катераар 360 градуст эргэлтийг аюулгүй гүйцэтгэх;
3. Зогсоолд завины хажуугийн хэсгээр аюулгүй байрлуулах;
4. Усанд унасан хүнд тусламж үзүүлэхүйц хэмжээнд дөхөж очих (тусламж үзүүлэхээр дөхөж очихдоо тухайн этгээдэд давлагаа үүсгэж, их хэмжээний усаар дарж, нөхцөл байдлыг хүндрүүлэхгүй байх);
5. Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх;
6. Завь, катерын хурдыг тохируулах ба хөдөлгүүрийн хүчин чадлыг тооцоолох;
7. Завь, катерыг зогсоолд байрлуулахаас гадна завь катерын их бие, урд тал, хойд талаас зогсоол болон усны урсгалд тохируулан бэхлэх зэрэг анхан шатны мэдлэг чадваруудыг бүрэн эзэмшсэн байна;
8. Далайд хэрэглэдэг уяа, зангилааг зангидах аргууд ба төрөл, зориулалтын талаарх мэдлэгтэй;
9. Ослын үед усан замын тээврийн хэрэгсэл дээр болон усан дээр байгаа хүмүүст тусламж үзүүлэхээр дөхөн очиход анхаарах зүйл, тээвэрлэж буй зорчигч болон ачаанд ямар нэгэн эрсдэл учруулалгүйгээр аврах ажиллагаа зохион байгуулах арга, техник;

10. Усан замын тээврийн хэрэгслийн /чиргуул/ зангуу, аргамжаа /олс, уяаг ган тросс/-г хэрхэн бэхлэх, түүний зориулалт ба ашиглалт, хөвөгч тэмдэг, түүний хэрэглээ, утгыг таних.
4. ЦАХИЛГААНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЦАХИЛГААНААР АЖИЛЛАДАГ БАГАЖ ХЭРЭГСЭЛТЭЙ АЖИЛЛАХ ҮЕЙИН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА
- Аливаа цахилгаан хэрэгсэлтэй харьцахын өмнө заавар, гарын авлагыг уншиж танилцах, зааврыг ойлгоогүй бол мэргэжлийн хүнээс туслалцаа авах, таамгаар ажиллахыг хориглоно.
  - Залгуурын сэрээний шонд тохирох залгуур ашиглана. Залгуурын сэрээний шонгийн тоо хэлбэр зөрөх нөхцөлд тохирох давхар залгагч (адаптер) ашиглана. Залгуурт тааруулах зорилгоор сэрээний шонгуудыг салгах, нугалах, тахийлгахыг хориглоно.
  - Цахилгаан багаж, машиныг өөрөө задалж ямар нэг засвар хийхгүй байх.
  - Цахилгаан багажийг ажиллаж байх үед утаснаас барих ба багажны эргэлдэх хэсэгт хүрч болохгүй.
  - Цахилгаан төхөөрөмжийг бүрэн зогссоны дараа үйлчилгээ хийх хэрэгтэй.
  - Цахилгаан машин, багажийг цахилгаан сүлжээнд залгаатай нь болон хараа хяналтгүй орхиж болохгүй.
  - Эд зүйлд болон хананд налуулан тавьсан шатан дээр цахилгаан багажаар ажиллахыг хориглоно
  - Цахилгаан багажаар ажиллах үедээ хамгаалалтын нүдний шил зүүсэн байх ёстой.
  - Багажтай ажиллаж байх үед цахилгааны утсыг нугалах, мушгих, дээр нь хүнд зүйл тавихыг хатуу хориглоно.
  - Цахилгаан багажийг нэг ажлын байрнаас нөгөөд зөөж шилжүүлэхдээ хүчдэлээс салгасан байх хэрэгтэй.
  - Цахилгаан багаж, тоног төхөөрөмжийг газардуулсан байх шаардлагатай.
  - Цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмжийг эх үүсвэрээс салгахдаа утаснаас зуурч татаж болохгүй, харин сэрээний бариулаар барьж татахыг анхаар. Утаснаас зуурч татсанаар, утас болон сэрээ, залгуурыг гэмтээх төдийгүй хүчдэлд цохиулах, гал түймэр гарах аюултай.
  - Гүйдэл дамжуулагч нь давхар тусгаарлагчтай байх. Багаж нь өөрөө залгагдаж, салгагдах нөхцөлгүй байх.
  - Багажны тэжээлийн утас ба кабелийг халуун, нойтон ба тостой гадаргуу болон биеттэй шууд шүргэлцэн хүргэхгүй байх.
  - Багажны тэжээлийн кабель нь шалбарсан хамгаалалтгүй ил гарсан байх ёсгүй
  - Ажил гүйцэтгэж дууссаны дараа ажлын байрыг эмхэлж цэгцлэн, багаж хэрэгслийг зориулалтын тавиур дээр тавих хэрэгтэй.
  - Цаг агаарын аюултай нөхцөлд задгай талбайд ажиллахыг хориглоно. /аянга, цахилгаан, бороо, цас, салхи, шуурга г.м/ Мөн тэсэрч дэлбэрэх аюултай ажлын байранд цахилгааны багажтай ажиллахыг хориглоно.
  - Ил задгай, чийглэг орчинд ашиглах залгуур, унтраалга, цахилгаан хэрэгслүүд нь хамгаалалттай байх ёстой
  - Унтраалгыг товчуур дарж унтраасан хэдий ч цахилгаан хүчдэл хэвээр оршиж байдаг тул үзлэг шалгалт, цэвэрлэгээ, засвар үйлчилгээ гүйцэтгэхийн өмнө тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, уртасгагч залгуурыг цахилгааны эх үүсвэрээс бүрэн салгах шаардлагатай. Цахилгааны 2 фазад зэрэг хүрч болохгүй.

- Агаарын температур, чийг ихсэхэд хүний биеийн эсэргүүцэл багасаж, организмын цахилгаан гүйдэл эсэргүүцэх чадвар буурдаг, агаарын даралт буурвал цахилгааны аюул ихэнэ гэдгийг анхаарч ажиллах хэрэгтэй.
- Ядарсан, өвчилсөн үед цахилгаан гүйдэлд мэдрэмтгий, өртөмтгий болдог. Ийм үед цахилгаан багаж хэрэгсэлтэй ажиллахаас зайлсхий.
- Цахилгаан дамжуулах утсыг аюулгүй ажиллагааны дагуу монтажилсан байх.
- Цахилгаан дамжуулах агаарын шугам тасарч газар унасныг мэдвэл 10 м-ээс дотогш ойртохгүй байх, зохих байгууллага, хүмүүст мэдээлэх.
- Тэсрэмтгий бодис агуулдаг байр, савны орчимд цахилгаан нум үүсэх буюу цахилгаан утсыг хөвж тавихаас зайлсхий.
- Шатамхай хий, хүчинтөрөгчөөр баялаг агаартай орчинд оч үсэрч мэдэх цахилгаан хэрэгслийг бүү хэрэглэ. Шатамхай хийн орчинд зөвхөн оч үсэргэдэггүй цохилтот багаж хэрэглэнэ.
- Розетка, вилка, унтраагуурын гадна талын хаалт хамгаалалт нь бүрэн бүтэн байх шаардлагатай.
- Аккумляторын батарейг задлах засварлах ажлыг зөвхөн задгай агаарт хийх бөгөөд хамгаалах хэрэгслийг хэрэглэнэ.
- Аккумляторын хүчдэлийн шонд гар, хуруугаа шууд хүрэх, зөвхөн резинээр бүрсэн хамгаалалтын бээлийтэй ажил, үүрэг гүйцэтгэнэ.
- Аврах завины аккумляторын өрөөнд гадны хүн оруулах, тамхи татах, ил гал гаргах, хүнсний зүйл хадгалах зэргийг хатуу хориглоно.
- Хэрвээ засварлах гэж байгаа цахилгаан шугамаас хүчдэлийг нь салгах болохгүйгээр байвал уг ажлыг аюулгүйн техникийн дүрмийн дагуу резинэн тусгаарлагч бээлийтэй, резинэн дэвсгэр дээр зогсож гүйцэтгэнэ.
- Цахилгаан тоноглолын таслагдсан хэсэгт хүчдэл байгаа эсэхийг хүчдэл заагчаар шалгах өргөх байгууламжийг ажиллаж байгаа үед нь ажил хийх аюултай байдаг учир цагирган контакт коллекторыг цэвэрлэх аппарат, бусад тоноглолд тохируулга хийхийг шууд хориглоно.
- Зөөврийн гэрлийн бариулыг дулаан чийгт тэсвэртэй материалыар хийх гэрлийн гүйдэл дамжуулагч хэсгийг хамгаалалттай байлгана.
- Цахилгаан төхөөрөмжийн эд анги хэсгийг танихын тулд тэдгээрийг өнгийн будгаар будаж ялгана. Хүчдэлтэй фазуудыг ногоон, шар, улаан өнгөөр нойлын фазыг хар өнгөөр будаж тэмдэглэнэ.
- Хүчдэл бүхий төхөөрөмж эд анги хэсгүүдэд хүн хүрэхээс найдвартай хамгаалахын тулд түүний хаалгыг үргэлж цоожтой байлгах. Ажлын байранд хаалт хийж, “ЗОГС, ӨНДӨР ХҮЧДЭЛ БҮҮ ХҮР, ӨНДӨР ХҮЧДЭЛИЙН ШОНД БҮҮ АВИР, ҮХЛИЙН АЮУЛТАЙ, БҮҮ ЗАЛГА, ШУГАМАНД АЖИЛ ГҮЙЦЭТГЭЖ БАЙНА, БҮҮ ОНГОЙЛГО” зэрэг тохирох анхааруулах санамжийг байрлуулах,
- Ажлын байранд хүчдэл байгаа эсэхийг гараар хүрч шалгахыг хориглоно.
- Трансформаторт гэмтэл, хэт халалт илрүүлбэл шугамд түр салгалтыг цахилгаанчнаар гүйцэтгүүлнэ.

## 5. ХЯНАЛТЫН ЗАВЬ, КАТЕРЫГ УСНААС ГАРГАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Завь, катерыг уснаас гаргахдаа дараах аюулгүй ажиллагааны зааврыг баримтлан ажиллана. Үүнд:

- Чиргуулийн дугуйны хий бүрэн эсэх,
- Завинд тохирох даац бүхий чиргуулийг сонгон хэрэглэх,

- Бэхэлгээний уяа бүрэн бүтэн эсэх,
- Чиргуулийн эд анги ачааллыг даахуйц, эвдэрч гэмтээгүй эсэх,
- Завь чиргуулд дээр хөдөлгөөнгүй, найдвартай ачигдаж, бэхлэгдсэн эсэх,
- Завины хүндийн төвийн тэнцвэрийг олж, аюулгүй байдлын хангах,
- Хэрэв автомшинаар чирэх тохиолдолд завь болон авто машины хооронд хангалттай зайд байгаа эсэхийг шалгах,
- Чиргуулийг чирэх автомашиндаа зөв бэхэлж, бүх холболтууд хоорондоо холбогдсон, аюулгүйн гинж найдвартай байгаа эсэх,
- Завийг өвлийн зогсоолд байршуулах үед цахилгаан трасс бүрэн ажиллаж байгаа эсэхийг урьдчилан сайтар шалгах,
- Зогсоолд завийг оруулахдаа хөдөлмөрийн аюулгүй байдлаа сайтар хангаж гар, хөлөө хавчуулахаас болгоомжлох,
- Урт хормойтой, салбагар сүл ханцуйтай цамц, нэвсгэр хувцас өмсөхгүй байх трасс утсанд орооцолдооос болгоомжлох,
- Аврах завийг уснаас гаргахдаа чирэх, татах /либотик/ төхөөрөмжийг ажиллуулах туршлагатай 2-оос доошгүй хүнтэй гүйцэтгэж байхаас гадна ачаа холбирох, унах аюултайг тооцож, аюулгүй ажиллагааг бүрэн хангана.
- Хяналтын катер, аврах завийг зогсоолд байрлуулсны дараа чиргуулийн арап, тэнхлэг дор тулгуур, бэхэлгээ хийх, дугуйн урд, хойд талд зориулалтын ивээс хийнэ.

## 6. ХЯНАЛТЫН КАТЕР БОЛОН АВРАХ ЗАВИНД ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ, ӨВЛИЙН БИТҮҮ ЗОГСООЛ /АЖЛЫН БАЙР/, ГАРААШТ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

- Хяналтын катер болон аврах завинд засвар үйлчилгээ хийх үед аюулгүй ажиллагааг ханган техник ашиглалтын дүрмийг мөрдөж ажиллана.
- Ажлын байрандаа амархан гал авалцах шингэн болон арчих материал хадгалахыг хориглоно.
- Засвар хийх үедээ ХАБЭА-н зааврыг чанд баримталж ажиллах ба бүрэн ажиллагаатай багаж хэрэгслээр засвар үйлчилгээ хийх,
- Ургал завсар, техникийн үйлчилгээний бүртгэл хөтлөх.
- Засвар үйлчилгээ эхлэхийн өмнөх ажлын байрны эмх цэгц, цахилгаан багаж хэрэгслийн ажиллагааг шалгаж, аюулгүйн шаардлага хангасан орчинд гүйцэтгэнэ.
- Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн хэрэглэж, аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан байна.
- Талбай нь тэгш бус, зөөлөн хөрстэй газарт техник байрлуулах, цаг агаарын таагүй нөхцөлд завсар үйлчилгээний ажил гүйцэтгэхийг хориглоно.
- Засвар үйлчилгээ хийх ажлын байрны гэрэлтүүлэг хангалттай байх ба нүд гялбуулахгүй байхад анхаарна.
- Завины эд ангиудыг засварлах ба турших үед санамсаргүй унахаас болгоомжлох, найдвартай зориулалтын тавиур, ширээн дээр байрлуулна.
- Тээврийн хэрэгслийн хүнд /15 кг-аас дээш жинтэй/ агрегат, эд ангийг өргөх, салгах, угсрал, тээвэрлэхдээ зориулалтын өргөх механизмыг ашиглана.
- Хөдөлгүүрт засвар үйлчилгээ хийхдээ зөөврийн өргөгч цамхаг ашиглах ба засварыг зориулалтын ажлын байранд гүйцэтгэнэ.
- Ачаа өргөх механизмын татлагад /трасс/ өлгөгдсөн техник хэрэгслийн дор байх, ажиллахыг хориглоно.
- Хортой хийнд хордооос сэргийлж, аврах завины хөдөлгүүрийг 5 минутаас илүү хугацаанд агааржуулалтгүй байранд удаан ажиллуулахыг хориглоно.

- Хяналтын катер болон аврах завины хөдөлгүүр ажиллаж байхад техникийн үйлчилгээний бүх төрлийн ажлыг гүйцэтгэхийг хориглоно. “ХӨДӨЛГҮҮР АСААЖ БОЛОХГҮЙ. ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙЖ БАЙНА” гэсэн санамжийг удирдлагын хэсэгт байрлуулах;
- Засварын ажлын үед хариуцсан мэргэжилтний зөвшөөрөлгүйгээр тоног төхөөрөмж, тохируулга шалгалт хийж, хүчдэл өгч хэрхэвч болохгүй.
- 18-аас дээш насны, сургалтад хамрагдсан, зааварчилгаа авсан хүнд тээврийн хэрэгсэлд засвар, техникийн үйлчилгээ хийхийг зөвшөөрнө.
- Засвар үйлчилгээ хийдэг байранд галын аюулгүй ажиллагааны дүрмийг хатуу мөрдөх ёстай. Үүнд:
- Шатах тослох материал арчсан алчуур, даавууг ил задгай хаяхгүй, цахилгаан, ил гал, нарны шууд тусгалаас хол байлгах,
- Хаалга, гал унтраах хэрэгсэл байгаа газар луу очих зам, хэсэгт юм овоолох тээврийн хэрэгслийг байрлуулах аргыг /схемийг/ зөрчих, амархан гал авалцах материалыг ил саванд хадгалахыг хориглоно.
- Материал, агрегатууд, сэлбэг хэрэгсэл зэргийг барилга, байгууламж, хашааны дэргэд замбараагүй байрлуулах, хадгалахыг хориглоно.
- Тээврийн хэрэгсэлд засвар, техникийн үйлчилгээ хийхдээ ачаа өргөх механизмууд дээр ажиллах зааварчилгаа, цахилгаан багаж хэрэгслийг ашиглах зааварчилгааг мөрдөх шаардлагатай.

#### **Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шаардлага**

- Ажлын хувцсыг эмх цэгцтэй болгох, ханцуйгаа товчлон, хувцсаа илүү дутуу унжуулахгүйгээр янзлан, үсээ малгай дотроо хийх. бензинээр засвар хийхдээ резинэн гутал, ханцуйвч, резинэн бээлий болон зохих ажлын тусгай хувцас өмсөнө.
  - Гэрийн шаахай, сандаалтай ажиллахыг хориглоно.
  - Ажлын байрыг анхааралтай харан, түүнийг эмх журамтай болгох. Саад болж буй бүх зүйлийг зайлуулах.
  - Хэрвээ зөөврийн цахилгаан гэрэлтүүлэг хэрэглэх шаардлагатай бол гэрэлтүүлэгт хамгаалалтын тор байгаа эсэхийг, тусгаарлах резинэн гуурс бүрэн бүтэн эсэхийг шалгана.
- Завин доор ажиллахдаа дэвсгэр буюу тусгай тэргэнцэр бэлдэх.
- Өөрийн ажлын байр луу гаднын хүн оруулахгүй байх.
  - бензиний сав, бензиний хоолойнд бензиний үлдэгдэл байгаа эсэхийг шалгах. агрегатудаас тос, усыг зөвхөн тусгай зориулалтын газарт юулнэ. Шалан дээр гоожсон тос буюу солидолыг нэн даруй хуурай элс, үртэс цацан, тусгай газарт цуглувна.
- Гагнуурын ажил гүйцэтгэхдээ бензин болон бензинд зөөврөлөхөд ашиглаж байсан савыг ойрхон байлгахыг хориглоно.

#### **ХОРИГЛОХ ЗҮЙЛС:**


- Зөвхөн ганц өргөх механизмаар /домкрат, таль г.м./ хөндийрүүлсэн автомашинд аливаа нэг ажил гүйцэтгэхийг. Дугуй салгахтай холбоотой ажил гүйцэтгэхдээ салгаагүй дугуйнууд дордоо хоёр тулгуур ивэх бус, харин автомашин дордоо тавиур буюу тусгай төхөөрөмж тавих шаардлагатай.
- Хөндийрүүлсэн автомашины /чиргүүл/ дор тавиурын оронд дугуйны обуд, тоосго болон бусад гарти тааралдсан зүйлс тавихыг.
- Урьдчилан буулгаагүй байж автомашинаас /чиргүүлээс/, түүнчлэн бүхээг дор буюу автомашины арал дор тавиур тавин, бүхээгийг хөндийрүүлэх замаар нумыг нь салгах буюу тавих.

- Хөдөлгүүр асаалттай байхад зарим нэг төрлийн тохиргоо, туршилтаас бусад техникийн үйлчилгээ, засвар хийх.
  - Чирэх дэгээнээс автомашиныг өргөх.
  - Өргөх механизмын даацаас хэтэрсэн ачаа өргөх /түр зуур ч гэсэн/ Тусгай баригчгүй трос, ган татлагад бэхлэх үедээ агрегатуудыг авах, тавих болон тээвэрлэхийг. Амархан гал авалцдаг, дэлбэрэх аюултай ачаа зөөдөг автомашин цистернд засвар хийхийн өмнө түүнийг ачааны үлдэгдлээс нь бүрэн цэвэрлэн найдвартай газардуулах хэрэгтэй.
- Этилжүүлсэн бензин буюу хортой шингэний цистерн буюу савны /резервуарын/ дотор талыг цэвэрлэн, засвар хийдэг ажилчин ажлын тусгай хувцас, гуурсан хорт хийн баг, хамгаалалтын бүс болон олсоор хангагдсан байх ёстой бөгөөд савны гадна талд тусгай зааварчилгаа авсан хоёроос доошгүй хүн байх ёстой.
- Аваар ослын үед мөрдөх аюулгүй ажиллагааны шаардлагууд Гал түймэр буюу аваар осол гарсан тохиолдолд механик инженерт яаралтай мэдэгдэн унтраах арга хэмжээ авна.
  - Осолдогчид эмнэлгийн анхны тусламж үзүүлэн, эмнэлгийн ажилтан дуудах буюу осолдогчийг эмнэлэгт хүргэнэ.
  - Гал түймрийг газар авах буюу аваар ослын үр дагаврыг төвөгтэй болгохгүй, хүмүүсийг аюулгүй газарт гаргах арга хэмжээ авах.
  - Объектыг цахилгаан эрчим хүчинээс салгах.

#### **Ажлаа дууссаны дараах аюулгүй ажиллагааны шаардлагууд**

- Ажлын байраа эмх цэгцтэй болгон, багаж хэрэгслээ багажны хайрцагт хийх. Хэрвээ автомашиныг тусгай тавиур дээр тавьсан бол төхөөрөмжийн найдвартай байдлыг шалган, автомашиныг өргөх механизмын ган татлагад /трос/ өлгөөтэй болохгүй. Орхиж Механикчид гүйцэтгэсэн ажил, ажлын дутагдал, тэднийг арилгасан арга хэмжээний тухай мэдэгдэх
- Нүүр, гарaa савантай бүлээн усаар угаах, хэрвээ этилжүүлсэн бензинтэй ажилласан бол амаа заавал зайллан шүршүүрт орох.
- Ажлын тусгай хувцсыг зориулалтын газарт өлгөх.
- Цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлгийг унтраах
- Энэхүү зааварчилгааны шаардлагыг биелүүлээгүй иргэн, албан тушаалтанд сахилгын болон холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх болно.

Далайн захиргааны даргын 2024 оны  
06. дугаар сарын 01-ны өдрийн 01 дугаар  
тушаалын турлав дугаар хавсралт



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХҮЙН ЗААВАРЧИЛГААНЫ БҮРТГЭЛИЙН МАЯГТ

/Өгсөн зааварчилгаа бичих/